

## Гарчиг

1.	Төслийн товч танилцуулга .....	1
1.1	Байршил, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээлэл .....	1
1.2	Уурхайн ажлын горим, хүчин чадал, ашиглалтын хугацаа .....	2
1.3	Ашиглалтын систем .....	2
1.4	Ил уурхайн үндсэн хэмжээс .....	2
1.5	Овоолгын төлөвлөлт .....	3
2.1	Хүн ам .....	5
2.2	Бүс нутгийн дэд бүтэц .....	5
2.3	Баянхонгор аймгийн өрхийн тоо (2003-2018) .....	5
2.4	Хөдөө аж ахуй .....	5
2.5	Галуут сумын нийгэм, эдийн засгийн байдал .....	5
2.6	Галуут сумын хүн ам .....	6
2.7	Галуут сумын хөдөө аж ахуй .....	6
2.8	Бүс нутгийн уур амьсгал .....	6
2.9	Гадаргуугийн ус .....	6
6.1	Техникийн нөхөн сэргээлт .....	15
6.2	Биологийн нөхөн сэргээлт .....	15
7.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	16
8.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	17
9.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
10.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	18
11.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	20
12.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	24
13.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	28
14.	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	29
15.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн .....	31


## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Хүснэгт 1. Аж аж ахуй нэгж болон, төслийн товч танилцуулга*

ТӨСӨЛ	ТӨСЛИЙН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	“Ар Эс И” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011556073 Регистрийн дугаар: 5990661
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ	Улаанбаатар хот, Баянзүр дүүрэг, 6 дугаар хороо, улз гол цолцолбор, 101 тоот
ТӨСЛИЙН НЭР	Сайрын худгийн Ташуугын булгийн хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
ТӨСЛИЙН БАЙРШИЛ	Баянхонгор аймгийн Галуут сумын Сүмбэр багийн нутаг Балган уул нэртэй газар
ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙ	657.98га

### 1.1 Байршил, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээлэл

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Балган уул” нэртэй газарт MV-06653 ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Ар Эс И” ХХК эзэмшдэг ба нийт талбайн хэмжээ нь 657.97 га байна.



*Зураг 1. Төслийн талбайн байршилын зураг*

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт Монгол Улсын байр зүйн зургийн М-47-57 хавтгайд байрладаг. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 690 км, Баянхонгор аймгийн төвөөс баруун хойш 65 км, Галуут сумын төвөөс 30 км, Дөвөнтийн уурхайгаас 4 км зайтай орших бөгөөд Галуут сумын нутагт харьяалагдана.

*Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицол*

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	100° 03' 49"	46° 25' 27"	7	100° 02' 50"	46° 24' 17.29"
2	100° 03' 49"	46° 24' 39"	8	100° 02' 50"	46° 24' 34"
3	100° 04' 34"	46° 24' 39"	9	100° 02' 08"	46° 24' 34"
4	100° 04' 34"	46° 23' 56.58"	10	100° 02' 08"	46° 24' 57"
5	100° 03' 26"	46° 23' 56.58"	11	100° 01' 26"	46° 24' 57"
6	100° 03' 26"	46° 24' 17.29"	12	100° 01' 26"	46° 24' 57"

**1.2 Уурхайн ажлын горим, хүчин чадал, ашиглалтын хугацаа**

Тус уурхай 2026 онд сард 1 сая.м<sup>3</sup> жилийн хугацаанд нийт 7.3 сая.м<sup>3</sup> уулын цул хөдөлгөх бөгөөд уул техникийн нөхцөлөөс хамааран ашиглалтын улирал бүр элс хөрсний хэмжээ жигд биш байна. Ташуугийн булаг алтны шороон орд нь улирлын чанартай ажиллах 5 дугаар сараас эхлэн 11-р сар хүртэл жилд 6 сарын хугацаатай ажиллана.

*Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног*

№	Үзүүлэлт	Хэмжээс
1	Хоног дахь ээлжийн тоо	2
2	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12
3	Ээлжин дэх амралт, сул зогсолт, цаг	2
4	Ажиллах цаг	10

**1.3 Ашиглалтын систем**

Уурхайн ашиглалтын систем дотоод авто тээвэртэй ашиглалтын систем юм. 2020 онд ордын ашиглалтын 1 дүгээр жил тул 11.5 га талбайд 2.5 сая.м<sup>3</sup> хөрсний гадаад овоолго үүсгэсэн. 2021 оноос хойших бүх хөрс дотоод овоолгод хураагдаж, ашиглалтын явцад уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг давхар гүйцэтгэж буйгаараа онцлог төсөл.

2026 оны тухайд 2021 оны олборлолтын хоосон орон зайг хөрсөөр дүүргэлт хийж дотоод овоолго хийж ажиллана. /Жич: 2022-2025 оны уурхай үйл ажиллагаа явуулаагүй/

**1.4 Ил уурхайн үндсэн хэмжээс**

Доголын өндөр: Ил уурхайн ажлын доголын өндрийг Нд=6 м байхаар тооцсон ба олборлолтын явцад 3-3.5 м-ын дэд доголоор ашиглалт явуулна. Энэ нь ажиллах экскаваторын техникийн параметрт уялдуулан тооцоолсон хэмжээ юм. Харин ажлын догол нь ажлын бус бүсэд шилжихэд нэгтгэн хурааж ажлын бус догол үүсгэх бодлогыг хэрэгжүүлнэ. Ажлын бус доголын өндөр нь Нд=12м байна. Үүний дүнд уурхайн ажлын бус бүсэд үүсэх замын уртыг багасгах замаар уурхайн хүрээний тээврийн зардлыг хэмнэх нөхцөл бүрдэх болно.

Доголын хажуугийн өнцөг. Ил уурхайн гүн нь харьцангуй бага учир ажлын доголын хажуугийн өнцөг  $\alpha=70^\circ$  байхад тогтвортой гэж үзэн сонгож авсан. Энэхүү хэмжээ төсөл зохиомжид мөрдлөг болгодог нөхцөлтэй зөрчилдөхгүй.

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн Ташуугийн булгийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Ажлын талбайн өргөн: Ил уурхайд ажиллах экскаватор болон автосамосвалын техникийн үзүүлэлтүүдээс шалтгаалан ил уурхайн ажлын талбайн хамгийн бага өргөн 20м-ээс багагүй байна

*Хүснэгт 4. Ашиглалтын системийн элемент*

Д/д	Ашиглалтын элемент, үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс
1	Ажлын доголын өндөр, Н <sub>д</sub>	м	3
2	Ажлын бус доголын өндөр, Н <sub>д</sub>	м	12
3	Ажлын доголын хажуугийн өнцөг, α <sub>д</sub>	град	70
4	Автозамын өргөн	м	25
5	Замын налуу	%	10
6	Ажлын талбайн бага өргөн, В <sub>атmin</sub>	м	20


*Хүснэгт 5. Ил уурхайд ашиглах тоног төхөөрөмжүүд*

№	Тоног төхөөрөмжийн нэр, марк	Үзүүлэлт	Тоо ширхэг	Зориулалт
1	Өрмийн машин- SWD 165A	165 мм	2	Хөрс
2	Экскаватор – CAT 390	5.3 м.куб	6	Хөрс
3	Экскаватор – CAT 385	4.8 м.куб	2	Хөрс
4	Экскаватор – CAT 349	2.8 м.куб	1	Туслах ажил
5	Автосамосвал – HOWO 105	70 т	12	Хөрс, дотоод овоолго
6	Автосамосвал – Tonly	50 т	10	Хөрс, элс тээвэр
7	Автосамосвал – CAT 773	50 т	4	Хөрс, дотоод овоолго
8	Бульдозер – CAT D8	5.5 м.куб	2	
9	Утгуурт ачигч – SEM 650	3.0 м.куб	4	Элс угаан баяжуулах цех
10	Усны машин	-	1	
11	Түлшний машин	-	1	

### 1.5 Овоолгын төлөвлөлт

Тухайн жилийн бүх хөрс өмнө олборлогдсон хоосон орон зайд нөхөн дүүргэлт хийгдэж дотоод овоолго үүсгэнэ. Нийт 7.1 сая .м3 хөрс хуулна.

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн Ташуугийн булгийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



*Зураг 2. Ил уурхайн процессын схем*

Тус уурхай 2026 онд сард 1.1 сая.м<sup>3</sup> жилийн хугацаанд нийт 7.3 сая.м<sup>3</sup> уулын цул хөдөлгөх бөгөөд уул техникийн нөхцөлөөс хамааран ашиглалтын улирал бүр элс хөрсний хэмжээ жигд биш байна. Ташуугийн булаг алтны шороон орд нь улирлын чанартай ажиллах 3 дугаар сараас эхлэн 11-р сар хүртэл жилд 8 сарын хугацаатай ажиллана.

## **2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

### *2.1 Хүн ам*

Тус аймаг нь 2018 оны байдлаар 9679 өрхийн 31685 хүн ам тоологдсон ба хүн амын сүүлийн 28 жилийн динамикаас харахад 1990-1998 он хүртэл тогтвортой байсан бөгөөд 1999 оноос хойш ерөнхийдөө тогтвортой өссөн байна.

### *2.2 Бүс нутгийн дэд бүтэц*

Галуут сум нь аймгийн төвөөс 95 км зайд алслагдсан. Нийт 6 багийн 1100 өрх бүхий 4200 гаруй хүн амтай. Тус суманд 10 жилийн сургууль, шуудан холбооны салбар (мобикомын сүлжээ) хүн, мал эмнэлэг, болон үйлчилгээний газруудтай.

### *2.3 Баянхонгор аймгийн өрхийн тоо (2003-2018)*

Тус аймгийн хэмжээнд сүүлийн 16 жилийн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоон мэдээнээс харахад тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Нийт өрх толгойлсон эмэгтэйн тоо 2018 оны байдлаар 3942 байна

### *2.4 Хөдөө аж ахуй*

Баянхонгор аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар нийт 14765 малтай өрх тоологдсон бөгөөд өрхийн тоо 1991-2000 он хүртэл тогтвортой байсан бол 2000 онд тоо толгой буурч 2001 онд 16000 толгой хүрчээ. Үүнээс хойд 2009 он хүртэл дахин тогтвортой өссөн бөгөөд 2009-2011 он хүртэл дахин буурах хандлага ажиглагдсан бол сүүлийн 10 жил тогтмол өсөх хандлагатай байна.

### *2.5 Галуут сумын нийгэм, эдийн засгийн байдал*

Галуут сум нь Улаанбаатар хотоос 728 км, аймгийн төвөөс 86 км зайтай. Хойд талаараа Архангай аймгийн Чулуут, Их Тамир сум Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Баян-Овоо, Бөмбөгөр, Заг, Жаргалант сумтай хил залгадаг. Баянхонгор аймгийн Галуут сум Монгол Улсын нэгэн түүхт хошуу, түүхт сум юм. Халхын 3 хошуу Цогтой гүн, Дархан гүн, Номун хан шавь одоогийн Галуут Бөмбөгөр Баацагаан сумын түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой. 1923 онд Цогтой гүний хошууг Баянхонгор хайрхан уулын хошуу гэж нэрлэн Баянхонгор, Хуримт нуур, Цагаан овоо, Бөмбөгөр хайрхан гэсэн 4 сум, 12 болгон хуваан байгуулжээ. Баянхонгор хайрхан уулын хошуу гэдэг нэр 1941 оныг хүртэл нэрлэгдэж байгаад БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 12-р сарын 11-ний өдрийн 81-р тогтоолоор Баянхонгор аймгийн Галуут сум гэж нэрлэх болсон.

Тус суманд есөн жилийн дунд сургууль, цэцэрлэг, хүний их эмчийн салбар, соёлын төв, харилцаа, холбоо, ус цаг уурын станц зэрэг төрийн үйлчилгээний байгууллагууд ажилладаг. Хангайн нурууны салбар уулс, хөндий хоолой дэл сэрвэн хосолсон 504,7 мянган га эдэлбэр нутагтай. Далайн түвшингээс дээш 3539 м өргөгдсөн Гурван Анагийн нуруу, хамгийн доор газар нь 2117 м өндөрт байрлах Баянхонгор хайрхан уулын өвөр юм. Сумын төв нь Баянхонгор хайрхан уулын өвөрт Харганын голын хойд хөндийд байрлана.



Зураг 3. Галуут сумын төв

## 2.6 Галуут сумын хүн ам

Галуут сумын хэмжээнд 2018 оны байдлаар 1264 өрхийн 4103 хүн ам оршин сууж байна. Тус сумын 1990 оноос 2018 он хүртэлх сүүлийн хорин найман жилийн хүн амын статистик тоон мэдээнд анализ хийж үзвэл 1999 оноос хүн амын тоо буурч байгаад сүүлийн хоёр жилд өсөх хандлагатай, өрхийн тоо 2013 оноос өсөх ерөнхий хандлага ажиглагдаж байна. Хүн амын нягтшил 2018 оны байдлаар 0.8 хүн/км<sup>2</sup> байна.

## 2.7 Галуут сумын хөдөө аж ахуй

Тус сумын хэмжээнд таван хошуу малын 1970-2018 оны хоорон дахь мэдээг харвал бод малын хувьд ерөнхийдөө буурах хандлагатай байгаа бол хонь ямаа өсөх хандлагатай байна. Малын тоо 2002 оноос хойш ерөнхийдөө өссөн ба ялангуяа 2011 оноос огцом өссөн нь доорх графикаас харагдаж байна. Сүүлийн 5 жил хонь болон ямааны тоо огцом өссөн байна. 2018 оны байдлаар нийт сүргээс тэмээ 90, адуу 1986 толгой, үхэр 3492 толгой, хонь 12662 толгой, ямаа 10807 тоо толгой байна.

## 2.8 Бүс нутгийн уур амьсгал

Цаг уурын хувьд район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадасны 85% нь зун ордог. Гадаргуугийн ус 10-р сарын сүүлээр хөлдөж, 4-р сард гэдэг. Баянхонгорын цаг уурын станцын мэдээгээр жилийн дундаж тундасны хэмжээ 254 мм болно. Өвөл хүйтэн, хамгийн хүйтэн сар нэгдүгээр сар (-430С хүрдэг). Хамгийн халуун нь долоо дугаар сар (+250С) байдаг. Зун сэрүүвтэр, харьцангуй богино, агаарын температур 15-300С-ийн хооронд хэлбэлздэг. Харин намрын сар урт, хуурай. Хавар сэрүүн, хүчтэй салхитай. Салхины хурд заримдаа 21.0 м/сек хүрдэг. Хааяа гэр оронг хийсгэсэн угалз болж хувирдаг. Жилийн дундаж температур -50С хүрдэг. Хөрсний хөлдөх гүн 2-3 м. Ашиглалтын болон хайгуулын талбай мөнх цэвдэгтэй бүсэнд хамаарна. Район нь тавдугаар сарын эхээр дулаарч, аравдугаар сарын дундуур хүйтэрдэг.

## 2.9 Гадаргуугийн ус

Усан сүлжээ гэж тус районд байхгүй мөн байнгын урсгалтай гол горхи байхгүй, бороо ус ихтэй жил сайр, жалга даган түр зуурын усны урсгалтай болдог. Усан хангамжийн эх үүсвэр нь худаг юм. Район нь ой модгүй, харин өвс ургамлын бүрхэвч сайтай газар юм.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Ташуугийн булаг алтны шороон ордын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийн нэгдсэн үнэлгээг хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, агаарын чанар, гадаргын болон гүний ус, ургамал амьтан гэсэн байгалийн үндсэн бүрэлдэхүүнүүдээр авч үзлээ.

Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Хөрс хуулах				Үр дүн	Элс угаан баяжуулах				Үр дүн	Дэд бүтэц					Үр дүн	Нийт дүн
		Тэсэлгээ хийх	Хөрс ,элс	Хөрс	Ачиж буулгах		Элс ачиж	Элс угаах	Баяжуулах	Цэвэр, бохир,		Уурхайн	Уурхайн	ШТС	Дизель станц	Хог хаягдал		
1	Агаарын чанар	4	3	3	3	13	3	0	2	0	5	2	2	2	3	2	11	29
2	Газрын хэвлий	4	4	2	0	10	4	0	0	3	7	2	2	3	0	0	7	24
3	Хөрсөн бүрхэвч	3	4	3	0	10	0	2	0	3	5	3	3	2	2	2	12	27
4	Гадаргын ус	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
5	Гүний ус	2	4	0	0	6	0	4	0	2	6	0	0	0	0	2	2	14
6	Ургамал нөмрөг	3	4	3	2	12	0	2	0	3	5	3	3	2	2	2	12	29
7	Амьтны аймаг	3	1	0	0	4	0	0	0	2	2	1	0	0	2	0	3	9
Нийлбэр дүн		19	20	11	5	45	7	8	2	16	30	11	10	9	9	8	47	

Нөлөөллийг үнэлэхдээ:

Их - 4


Дунд - 3

Бага - 2

Маш бага – 1

Нөлөөлөлгүй – 0

Баллаар болон оноот үнэлгээ өгч үнэлсэн



**Агаарын чанар:** Алтны шороон ордын төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд тэсэлгээ хийх, шимт хөрс болон үндсэн хөрс хуулах, элс олборлох, ачих, буулгах, тээвэрлэх үйл ажиллагаанаас хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

**Газрын хэвлий:** Төслийн үйл ажиллагаанаас хөрс хуулах, элс олборлох ажлын үед газрын хэвлийд хамгийн их сөрөг нөлөөлөл учруулахаар байна. Элс угаах болон, дэд бүтцийн байгууламжийн үйл ажиллагаанаас газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл байх боловч хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага юм.

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл их байх бөгөөд нөлөөлөлд өртөх объект нь уулын ажилд өртөх талбай, элс угаан баяжуулах цехийн үйл ажиллагаанд өртөх талбай, дэд бүтцийн байгууламжуудад өртөх талбайн хөрсөн бүрхэвч хамаарна. Үүнээс гадна хатуу болон шингэн хог хаягдлын ил задгай хаях, ШТМ газрын гадаргад алдах зэргээс хөрсөн бүрхэвчийг бохирдуулах, олон салаа зам гарган талхагдалд оруулах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй юм.

**Гүний ус:** Хөрс хуулалт болон элс олборлох ажлын үед хөрний шүүрлийн ус орж ирх бөгөөд шүүрлийн усыг насосоор шавхан авч уурхайн тоосжилт дарах ажилд ашиглах замаар гүний усны нөөцыг бууруулана.

**Ургамлан нөмрөг:** Төслийн бүхий л шатны үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн их байна. Үүнээс гадна хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаях, олон салаа зам гаргах, тоосжилт ихээр үүсгэх, уурхайн тухайн жилийн төлөвлөлтийн хэмжээнээс хэтрүүлэн газар хөндөх зэргээр ургамлан нөмрөгийг талхагдалд оруулах, тоосжилтын нөлөөгөөр ургамлын фотосинтезийн эрчмийг бууруулах сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй юм.

**Амьтны аймаг:** Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл бага бөгөөд төслийг хүчин чадлаас хэтрүүлэн ажиллах, ажилчид хулгайн ан хийх, их хэмжээний давтамж бүхий дуу чимээ үүсгэх, уурхайн ухааш, хиймэл нуур зэрэгт хаалт хашилт хийгээгүйн улмаас мал, амьтан унаж бэртэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Дээрх үнэлгээний хүснэгтээс төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрдэл хэсгүүдэд хамгийн их сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хэсэг ургамал нөмрөг, хөрс орчин, агаар орчин бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас хөрс хуулах, элс угаан баяжуулах хэсгээс байгаль орчны бүрдлүүдэд хамгийн их сөрөг нөлөөлтэй болох нь харагдаж байна.

#### **4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтдээ тусган гүйцэтгэнэ.

2026 онд Байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг багасгах, түүнийг бууруулах, хянах чиглэлээр Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, БОМТөлөвлөгөөг баталсан байгууллага болох Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж хянуулж батлуулан мөрдөж ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлуудыг дараагийн бүлгүүдэд тусгасан болно.

Уул уурхай ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргээхгүй газрын биологийн олон янз байдлыг төлөөлүүлэн өөр газарт хамгаалах зорилгоор Төв аймгийн БОАЖГ-аас дүйцүүлэн хамгаалах талбайн талаар санал авах

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
Төсөлд ашиглагдах машин механизм, дизель станцын яндангаас ялгаран гарах утаан дах агаар бохирдуулагч хорт хийнүүд орчинд тархах	Уурхайн бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж байх.	Уурхайд ашиглагдаж байгаа бүх машин техник	ш	43	30.0	2,070.0	Байнга	Агаарын тухайхууль 9, 11,23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
Мөн салхи ихтэй үед их хэмжээгээр тоос шороо дэгдэх, машин механизмыг богино зайд олон эргэлттэйгээр ашигласнаас агаар дах тоосжилт ихсэх	Уурхайн замуудад усалгаа хийх замаар тоосжилтыг бууруулах	Уурхайн дотоод замуудад	км	5	ҮАЗ-аар	Доторхой график боловсруулсны дагуу		

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Гол болон нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Дүн						2,070.0		
<b>2. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>								
Байнгын хөл хөдөлгөөнөөс байгууламжуудын ойр орчмын хөрсөн бүрхэвч доройтох, элэгдэл эвдрэлийн талбай нэмэгдэх.	Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, баталсан маршрутаар явуулж хэвшүүлэх, салаа зам гаргуулахгүй байх	Уурхайн дотоод замууд	ш	5	80.0	400.0	Төсөл хэрэгжиж буй нийт хугацааны туршид байнга	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. “Газрын тухай” хууль 50 дугаар зүйл
	Шимт хөрсийг стандартын дагуу хуулан, бусад хөрс чулуулагтай холилдохгүй байх тал дээр анхааран зөв зохистой байршуулах, үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх тал дээр	Төслийн хэмжээнд	удаа	Хуулсан хөрсний хэмжээгээр	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны зардлаар		

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Гол болон болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	анхаарч ажиллах							
<b>Дүн</b>						400.0		
<b>3. Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>								
Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч устана.	Уурхайн тосгоны талбайд ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтыг сайжруулах, нэмэгдүүлэх	Уурхайн тосгон	га	2.0	365.0	730	Ургамал ургалтын хугацаанд багтаан хийж гүйцэтгэх	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2008
<b>Дүн</b>						730.0		
<b>4. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>								
Уурхай орчмын газрын доорх усны түвшин буурч, нөөц багасах, бохирдол үүсэх	Усны газраар ус ашиглах дүгнэлтийг гаргуулан ажиллах	Төслийн хэмжээнд	удаа	1	-	-	2026 оны 2-р улиралд багтаан	MNS0900:2018-Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 4943: 2015
	Ус ашигласны төлбөр төлөх	Төслийн хэмжээнд	м <sup>3</sup>	Ашигласан хэмжээгээр (86,774.0 м <sup>3</sup> /жил)	ҮАЗ	ҮАЗ	2026 оны 4-р улиралд багтаан	-Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус.
	Тунгаагуур нуурууд болон уурхайн унд ахуйд хэрэглэж	Төслийн хэмжээнд	удаа	2	ОХШХ-ийн зардлаар		2026 оны 3-р улиралд багтаан	

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Гол болон нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	буй усны эх үүсвэрүүд зэргээс тогтмол хугацаанд дээж авч бохирдлыг хянаж ажиллах замаар үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх							Ерөнхий шаардлага
<b>Дүн</b>					<b>ҮАЗ+ ОХШХЗардал</b>			
<b>5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>								
Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалах	Үлийн цагаан оготно ихээр тархсан бэлчээрт махчин шувууны үүрнүүд байршуулах /Галуут сумын ЗДТГ, байгаль орчныг хамгаалах	Төсөл хэрэгжих талбайн ойролцоох бэлчээр нутагт	ш	10	50.0	500.0	2026 онд 3-р улиралд багтаан	Амьтны тухай хууль

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Гол болон болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	албанаас зөвлөгөө авах/							
<b>Дүн</b>						<b>500.0</b>		
<b>Нийт дүн</b>						<b>3,700.0</b>		

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 6.1 Техникийн нөхөн сэргээлт

Ил уурхайн ашиглалтын явцад хөрс хуулалтаар их хэмжээний хоосон орон зайг газрын гүний хурдас чулуулгийн дотоод овоолгоор дүүргэлт хийнэ.

Ташуугийн булаг алтны шороон ордыг уурхайн үйл ажиллагаанд 2026 онд 12.8 га өртөнө. Хөрсний дотоод овоолгод нийт 7,116.9 мян.м<sup>3</sup> хөрс мөн ашигласан эфель, гаалийг уурхайн нөхөн дүүргэж тэгшилнэ.

Ашиглалтын явцад буюу хуулсан хөрсийг шууд ашиглагдсан орон зай нөхөн дүүргэлт хийх байдлаар уулын ажлыг техникийн нөхөн сэргээлтийн ажилтай давхар явуулахаар төлөвлөж ажил гүйцэтгэх нь ихээхэн зардал болоод цаг хугацааг хэмнэх төдийгүй, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа юм.

Техникийн нөхөн сэргээлтийг хийх дийлэнх зардал нь ашиглалтын зардалд шингэх бөгөөд шимт хөрсөөр хучилт хийх үед ахин хэвгийжүүлэх, гадаргуугийн хэлбэр засах, дагтаршуулах ажил хийгдэнэ. 2026 оны хувьд дотоод овоолго хийж техникийн нөхөн сэргээлт хийх боломжтой талбайг 3.2 га байхаар тооцсон.

Уурхайн олборлолтын ахилт хийх бүрт шимт хөрс буюу гадаргуугаас 0.2 м зузаан ургамлын хөрс бүхий үеийг ангилан хуулж холбогдох стандарт, зааврын дагуу олборлолтын дараах нөхөн сэргээлт хийхэд өнгөн бүрхүүлийг хучих зорилгоор тусгайлсан овоолгод хадгална. Шимт хөрсийг бульдозероор хуулна. Шимт хөрсний овоолгын өндөр 5 м-ээс илүүгүй байна.

Ашиглалтын блокийг хааж дахин үйл ажиллагаа явуулахгүй /зорчихгүй/ нөхцөл бүрд биологийн нөхөн сэргээлт хийх бэлтгэл ажлыг хангах зорилгоор үржил шимт хөрсийг техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд 0.2 м-ийн зузаантай тараан байршуулна.

### 6.2 Биологийн нөхөн сэргээлт

2026 дотоод овоолго хийж хүлээлгэн өгсөн 2 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөсөн.

Биологийн нөхөн сэргээлтийг эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах Монгол улсын MNS 5918:2008 стандартын дагуу зардлын тооцооллыг хийсэн. Нөхөн сэргээлтийн ажлын зардлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

*Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал*

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэмжих нэгж	тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Техникийн нөхөн сэргээлт	Үйл ажиллагааны зардлаар хийх дотоод овоолго		3.2 га 7.1 сая.м3	-		
2	Биологийн нөхөн сэргээлт	БНС	га /м3/	2.0	11,100.0	VIII сар	
		Үйл ажиллагааны зардлаар хийх Шимт хөрсөөр хучих		2.0			
<b>Нийт</b>					<b>11,100.0</b>		

## 7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төсөл эхлэсэн буюу 2020 оноос эхлэн Баянхонгор аймгийн БОАЖГ-ын саналын дагуу хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагаагаар эвдэгдэж нөхөн сэргээлгүй орхигдсон нийт 5.1 га талбайг нөхөн сэргээж хүлээлгэн өгсөн байдаг.

2026 онд уг ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба Баянхонгор аймгийн БОАЖГ болон Баянхонгор аймгийн Галуут сумын засаг даргын ТГ-аас өгсөн чиглэлийн дагуу техникийн сэргээлтийг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэх	Дөвөнтийн ам орчимт орших 1 га талбайг нөхөн сэргээж хэлбэржүүлнэ.	1	8,850.0 /талбайг тэгшилж түрэх, хэлбэржүүлэх ажлын зардал/	8, 000.0	2026 оны 3 болон 4 др улиралд
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажилд зарцуулах ажилд</b>					<b>8,000.0</b>	

## **8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашигт малтмалын талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй.

## **9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ташуугын булаг алтны шороон ордын талбайд хийгдсэн археологи, палентологийн хайгуул, судалгааны ажлын үр дүнд тус талбайд ямар нэгэнд дурсгалт зүйл, олдвор илрээгүй тул түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө тусгайлан боловсруулах шаардлагагүй боловч Тухайн онд явуулах уул уурхайн олборлолтын явцад ямар нэгэн байдлаар түүх соёлын дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд ажиллах болно.

## 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Зардал, мян.төг		Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, дүрэм, журам
				Нэгж	Нийт		
Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар нийт ажиллагсдын дунд сургалт зохион байгуулах	Уурхайн эдэлбэр газарт	Төсөл хэрэглэгдэх хэмжээгээр	ХАБЭА-ын зардалаар	Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17)	
	Уурхайн цогцолборын болон хаягдлын сангийн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах						Уурхай эхлэхийн өмнө
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Гэнэтийн аваар ослын үед шаардлагатай гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт	Уурхайн объектуудад			Жилд 1 удаа	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”	

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах					
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах	Төслийн нийт ажиллагсдад	удаа		Жилд 1 удаа	MNS5078-2001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” MNS 5390:2004, “ХААЭА.
Дүн				ХАБЭА-ын зардлаар гүйцэтгэх		

## 11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежмент

Хаягдлын төрөл	Эх үүсвэр	Зайлуулах/устгах болон дахин ашиглах арга
Автомашинд ашиглагдсан хаягдал тос, тосны фильтр	Засварын газар, засвар үйлчилгээний машин	Төслийн талбай дээр цуглуулж, тусгай зөвшөөрөл бүхий хаягдал боловсруулах байгууламжид устгуулах буюу дахин боловсруулахаар хүргүүлнэ.
Хаягдал тосны савнууд	Засварын газар, засвар үйлчилгээний машин	Төслийн талбай дээр юүлнэ. Торхнуудыг дахин ашиглуулахаар бэлтгэн нийлүүлэгч рүү хүргүүлэх эсвэл зохих зөвшөөрөл бүхий байгууламжид устгана.
Хаягдал металл, торхнууд	Төслийн дэд бүтцийн хэсэг, суурин, оффис, засварын цех	Төслийн талбай дээр ангилан цуглуулна. Дахин ашиглуулахаар тээвэрлэнэ.
Ердийн хог хаягдал. Тухайлбал, биологийн задралд хялбар ордог органик (хоолны хаягдал), дахин боловсруулахад тохиромжгүй зарим хуванцар болон цаас	Уурхайн тосгон, захиргааны байр болон засварын газар	Төслийн талбай дээр ангилан, цуглуулна. Зохих зөвшөөрөл бүхий цэгт зайлуулж, устгана.
Дахин боловсруулах боломжтой хог хаягдал. Тухайлбал, цаас, цаасан хайрцаг, хуванцар, шил, хөнгөнцагаан лааз г.м.	Уурхайн тосгон, захиргааны байр болон засварын газар	Төслийн талбай дээр ангилан, цуглуулна. Дахин ашиглуулахаар тээвэрлэнэ.
Ашиглагдсан дугуй	Засварын газар	Хөнгөн тэрэгний дугуйнуудыг талбай дээр хадгалан, зөвшөөрөл бүхий байгууламж руу тээвэрлэн дахин ашиглах эсвэл устгана. Уурхайн машин механизмын дугуйнуудыг төслийн талбайд булж устгах бөгөөд тэдгээрийн байршлыг бүртгэлжүүлэх шаардлагатай.

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хаягдлын төрөл	Эх үүсвэр	Зайлуулах/устгах болон дахин ашиглах арга
Автомашины аккумулятор	Засварын газар	Төслийн талбайд тусгаарлан хадгалж, дахин ашиглуулахаар тусгай зөвшөөрөл бүхий байгууламж руу тээвэрлэнэ.

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
Ахуйн гаралтай хог хаягдал	Ахуйн гаралтай хог хаягдлыг өмнөх онд бий болгосон хогийн цэгт төвлөрүүлэн хуримтлуулах	Төслийн хүрээнд	тн	-	Гарсан хэмжээгээр	-	Тухай бүрт	Хог хаягдлын тухай хууль 9-р зүйл. MNS 5344:2011 Хог хаягдлын тээвэрлэлт, ангилал, ерөнхий шаардлага
	Хог хаягдлын гэрээг СЗД-тай байгуулан ажиллах, хог хаягдлын төлбөрийг цаг тухайд нь төлөх		удаа	600.0	1	600.0	Оны эхэнд гэрээ байгуулах, цаг тухай бүрт нь төлөх	
	Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу кодлон ангилах журмын дагуу ангилж хадгалах, эх		тн	ҮАЗардал	Үүссэн хэмжээгээр	200.0	ҮА-ны туршид	

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	үүсвэрээс зайлуулах арга хэмжээнүүдийг авч ажиллах							
Үйлдвэрийн гаралтай хог хаягдал	Хоосон чулуулгийн хаягдлыг өмнөх онд бий болсон карьерийг булах, нөхөн дүүргэх ажлуудыг зохион байгуулж ажиллах	Төслийн хүрээнд	мян.м <sup>3</sup>	ҮАЗардал	ҮА-ын хэмжээнээс хамаарч	ҮАЗардал	ҮА-ны туршид	
Аюултай хог хаягдал	Санамсар болгоомжгүйгээр ШТМ болон бусад аюултай шингэн хог хаягдал хөрсөнд ил задгай асгарсан тохиолдолд даруй тухайн хөрсийг хуулан авч, саармагжуулах, хоргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах.	АМТЗ-ийн талбай болон засварын талбайн хэмжээнд	удаа	15.0	10	350.0		Хог хаягдлын тухай хууль 9-р зүйл
	Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдэд ашиглагдсан	Төслийн хэмжээн д	Удаа	ҮАЗардал	ҮА-ын хэмжээнээс хамаарч	100.0	ҮА-ны туршид	Хог хаягдлын тухай хууль

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай  
зөвшөөрөлтэй Сайрын худгийн “Ташуугийн булаг”-ийн хэсгийн алтны шороон  
ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	аккумулятор, тос, тосны шүүр, фильтр зэргийг тусгайлан ангилж, агуулахад хадгалах ба тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс нь аюулгүйгээр зайлуулах							
Дүн						1,250.0		

## 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар уг төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулна.

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (2026 он)

Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, Мян.төг/жил	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
<b>1. Агаарын чанар</b>							
Ялгарах бохирдуулагчид: SO <sub>2</sub> , CO, NO <sub>2</sub>	Уурхайн талбайд 3 байршилд	Жилд хоёр удаа	2	500.0	1,000.0		Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585:2016), MNS 5919:2008 Дулааны цахилгаан станцын агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5013:2001 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ MNS ISO 4221: 2002, Агаарын чанар. Орчны агаарын хүхрийн давхар ислийн агуулгыг тодорхойлох; MNS 5365:2004, Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга;
Тоосны хэмжилт: PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> Тоосны чөлөөт Уналт Тоосны найрлага, бүтэц Тоосны тархалт	Уурхайн талбайд 3 байршил	Жилд хоёр удаа	2	200.0	400.0		
<b>2. Усан орчинд</b>							

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн "Ташуугийн булаг"-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, Мян.төг/жил	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Ca, Mg, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , HCO <sub>3</sub> , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин	Уурхайн унд-ахуйн хэрэглэгдэх худгийн уснаас болон технологит ашиглагдаж буй тунгаах нуураас	Жилд хоёр удаа	2	200.0	400.0		MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт (MNS 6148:2010) MNS (ISO) 4867:1999 Усны чанар – Дээжлэх Хэсэг 3: Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж MNS (ISO) 5667 11:2000 Усны чанар Дээж авах: 11-р хэсэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж MNS (ISO) 5667-1:2002 Усны чанар- Дээж авах: 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар
<b>3. Хөрсөн бүрхэвч</b>							
Хөрсний өнгөн болон дээд үе давхаргын элсжилт, чулуужилт, тоосжилт зэрэг морфологи тогтоцын өөрчлөлтийг хянах	Уурхайн талбай орчимд 3 цэгт /эврэлд өртсөн болон өртөөгүй талбайдыг хооронд нь харьцуулалт хийх байдлаар	Жилд хоёр удаа	2	200.0	400.0		MNS:3297:1991 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ. MNS:2305:1994 Хөрсний дээж авах, савлах, тээвэрлэх хадгалах журам MNS:3298:1991 Хөрсний шинжилгээнд дээж авах тавигдах ерөнхий зарчим.

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Сайрын худгийн "Ташуугийн булаг"-ийн хэсгийн алтны шороон ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, Мян.төг/жил	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
	тооцон дээж авах/						Хөрсний дээжийг нарийвчлал өндөртэй AAS зэрэг багажит анализын аргаар хяналтын СП ашиглан давталттай шинжлүүлэх. Шинжилгээний дүнг үндэсний стандарт болон ОУ-ын стандарттай жишиж дүгнэлт гаргах
<b>5. Ургамлан нөмрөг</b>							
Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалын тоо Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га Ургамлын үрийн банк Ургамлын нягтшил 1м <sup>2</sup> /бодгаль Тоосжилтын нөлөө	Уурхайн талбай орчимд 3 цэгт Нөлөөлөлд өртөөгүй буюу харьцуулах хяналтын 2 цэгүүдэд	Жилд хоёр удаа	2	500.0	1,000.0		Мониторингийн цэг бүрт судалгааг 25х 25 м <sup>2</sup> талбайд 1 удаагийн давталттайгаар хийх. Мониторингийн судалгааны өмнө тухайн бүлгэмдэл болон талбайн фото зургийг авч баримтжуулах, Тухайн мониторингийн цэг нь ямар бүлгэмдэлд хамаарагдаж буйг тодорхойлох, 1х1 м талбайд: Бүрхэцийг тусгагийн аргаар үнэлэх, Зүйл бүрийг бүртгэх, Тухайн зүйлүүдийн бодгаль бүрийг тоолох, Зүйл тус бүрийн дундаж өндрийг хэмжиж, Зүйл бүрийн фенологийн үе шатыг тэмдэглэх, Тухайн талбайгаас ургамлын биомассыг зүйл тус бүрээр газрын

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай  
зөвшөөрөлтэй Сайрын худгийн "Ташуугийн булаг"-ийн хэсгийн алтны шороон  
ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, Мян.төг/жил	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
							гадаргуутай тэнцүүлэн авч, дээжийн агаарын жинг авах,
<b>Нийт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал</b>					<b>3 200.0</b>		

### 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он		
1	Сум, багийн удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	Тухайн үед төлөвлөж зарцуулах	2026 онд	Уурхайн дарга	
2	Тус уурхайд ажиллаж байгаа ажилчдыг сургалтад хамруулж мэргэшүүлэх, чадавхийг нь дээшүүлэх	500.0	2026 онд 2 удаа	Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан	
3	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	ХАБЭА-ын зардлаар	2026 онд улирал бүр	Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан	
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	800.0	2026 онд	Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан	
5	БО-ны аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гэрээлэн хийлгэх	ҮАЗ	2026 оны 2-р улиралд багтаан	Захирал	
6	Дараа жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулахад бэлэн болгох	ҮАЗ	2026 онд сүүлийн улиралд	Уурхайн дарга	
Нийт		1 300.0			

#### 14. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Манай байгууллага үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Баянхонгор аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх ба бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 12-р сард багтаан хүргүүлнэ.

Хүснэгт 15. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар	Шаардлагатай тохиолдол бүрт хийгдэж буй ажлуудыг газар дээр нь хянуулан шалгуулж ажиллах /Бичгээр санал, шүүмж авах/	Тухайн онд хийгдэж буй ажлуудын тухай	Төсөл хэрэгжиж буй талбай дээр шалгалтаар очсон тухай бүрт	ҮАЗ	Уурхайн дарга	Уурхайн талбай дээр
Баянхонгор аймгийн БОАЖГ газар	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, тайлан хэлбэрээр хүргүүлэх ба шаардлагатай тохиолдолд зохиогдох хуралд илтгэл хэлбэрээр тайлагнана. /БОМТ-ний	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2026 оны 12 дугаар сард багтаах	500.0	Уурхайн дарга болон компанийн захирал	Баянхонгор аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.

**Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших MV-016653 тоот ашиглалтын тусгай  
зөвшөөрөлтэй Сайрын худгийн "Ташуугийн булаг"-ийн хэсгийн алтны шороон  
ордын 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	хэрэгжилтийн тайланг баталгаажуулах/					
БОАЖЯ-ны ХБОБНУГазар	БОМТ-ий биелэлтийн тайланг А-618 тоот журмын дагуу боловсруулан хүргүүлж, хянуулан батлуулах /БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах/	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2026 оны 12 дугаар сард багтаах	550.0	Уурхайн дарга болон БО-ны асуудал хариуцсан ажилтан	Багийн төвд
<b>Нийт</b>				<b>1050.0</b>		

## 15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ДҮН

Хүснэгт 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,700.0
2	Нөхөн сэргээлт хийх, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	11,100.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	8,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-ын зардал
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,250.0
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	3 200.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1 300.0
10	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	1 050.0
<b>2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b>		<b>29,600.00</b>